


ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ

ТОВХИМОЛ

9

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН
ОРОЛЦОО



Хөдөлмөр,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Save the Children

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 оронд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж, Боловсрол, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн хүрээнд үйлажиллагаагаа явуулж байна.

©Хүүхдийг Ивээх Сан, 2016 он

Боловсруулсан: Л.Бадамцэцэг
Хянан тохиолдуулсан: Х.Өлзийтунгалаг
Гарын авлагын зургийг Г.Ганбаяр

Хүүхдийг Ивээх Сан
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
I дүгээр хороо, Аризона төв, 4-р давхар

Шуудангийн хайрцаг:
Төв шуудан, ш/х-1023, Улаанбаатар хот 13, Монгол Улс

Утас: +976-11-329365,
+976-11-329371

Факс: (976-11) 329361

И-Мейл: secretary@savethechildren.mn

Facebook: Save the Children in Mongolia

Twitter: Save the children MN

Вэб: www.savethechildren.mn

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ БА ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

1990—ээд оноос зах зээлийн эдийн засаг хөгжиж, түүнтэй зэрэгцэн архидалт, ажилгүйдэл, ядуурал, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр, биеэ үнэлэлт зэрэг нийгмийн асуудлууд олноор гарах болж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаагаа эрчимтэй хэрэгжүүлэх болов. Нийгмийн үйлчилгээ хүргэж буй төрийн бус байгууллагуудын үндсэн чиглэлүүдийн нэг нь хүүхдийн хамгааллын асуудал юм.

Хүүхэд хамгаалал бол нийгмийн салбар дундын олон мэргэжилтэн, байгууллагуудын оролцоо, зохицуулалт бүхий, нарийн төвөгтэй асуудал бөгөөд манай орны хувьд төрийн анхан шатны нэгж болох сум, хороо, багийн түвшинд хүүхэд хамгааллын хамтарсан баг ажиллаж байна.

Монгол Улсын Төрийн бус байгууллагын тухай хуулийн (9.5)-д, “Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн төрийн бус байгууллагыг оролцуулж болно” гэж заасан байдаг. Энэхүү заалтыг үндэслэн 2007 онд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвөөс санаачлан, нийслэлийн бүх хороодод гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Хамтарсан багийг байгуулах тухай Нийслэлийн засаг даргын 144 дүгээр тоот захирамж гарсан нь өдгөө хүүхэд, гэр бүлийн нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гол нөлөө үзүүлж байна.

2016 оны 2 сарын 5-ны өдөр батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхэд хамгааллын үйлчилгээг хамтарсан багаар үзүүлэхийг хуульчлан өгснөөр үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.



ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА ОРОЛЦОХ НЬ

Хүүхэд хамгааллын тухай (2016) хуульд Хамтарсан баг гэж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг хэлнэ гэж тодорхойлжээ.

18.1. Хүүхдийн эрхийг хангах талаар иргэн, хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

18.1.1. хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

Хүүхдийн эрхийн тухай хуулиас

Өнөөгийн практикт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хамгийн үр дүнтэй хэлбэр нь төрийн нийгэм, эрх зүйн анхан шатны үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа мэргэжилтнүүд нэгдэн ажиллах хамтын ажиллагаа бөгөөд энэхүү аргачлалыг хамтарсан багаар ажиллах гэж нэрлэж, хэвшжээ.

Хамтарсан багаар ажиллах арга зүй нь нийгэмд үзүүлж буй ач холбогдлоороо төрийн болон төрийн бус байгууллагуудын анхаарлыг татаж, үйл ажиллагааны арга зүй болж, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг дэмждэг олон улсын байгууллагууд ч үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд туслалцаа үзүүлж байна.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Хүүхэд хамгааллын нэгж 2003 оноос Их Британий Хүүхдийг Ивээх Сангийн дэмжлэгтэйгээр гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах зорилгоор ажиллах олон нийтэд түшиглэсэн Хамтарсан багийн үйл ажиллагааг анх санаачилж хэрэгжүүлж байсан. Улмаар 2007 онд Улаанбаатар хот, Баянхонгор, Дорнод, Дархан-Уул, Өмнөговь, Завхан, Увс, Ховд, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв зэрэг аймгийн Засаг дарга нар тухайн орон нутгийн харьяа нутаг дэвсгэрийн сум, дүүрэг, хороо, багт тодорхой албан тушаалтнуудаас бүрдсэн Хамтарсан баг бүрдүүлж, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх тухай захирамж гаргаж баталгаажуулж байсан юм. Энэ загвар үндэсний хэмжээнд амжилттай түгэн дэлгэрэхэд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Монголын эмэгтэйчүүдийн сан, Хүүхдийн эрх хамгаалал төв, НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF), НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO), Хүүхдийг Ивээх Сан, Дэлхийн Зөн Монгол зэрэг үндэсний болон олон улсын ТББ-ууд чухал хувь нэмэр оруулсаар ирсэн.

Засаг захиргааны анхан шатны нэгж дээр Хамтарсан баг байгуулагдан ажиллах нь гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид өөртөө хамгийн ойр байдаг засаг захиргааны нэгжээсээ төрийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд, шуурхай авах боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Хамтарсан баг үүсэн байгуулагдсан хөгжлийн эхний үеэс эхлэн эдүгээг хүртэл төрийн бус байгууллагын санаачлага, арга зүйн дэмжлэгтэй улам бүр хөгжиж төрийн үйлчилгээний нэг хэлбэр болж байна.

Хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд, хүүхдэд, гэр бүлд нь шийдвэрлэвэл зохих олон асуудал гарч ирдэг.

Гэр бүл дэх хүүхдийн эсрэг хүчирхийллийн онцлог ба хөндлөнгийн оролцооны зураглал



Хүчирхийлэлтэй харилцааг илрүүлэх, шуурхай таслан зогсоох, хүчирхийллийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хохирогч болон гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүй, эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн сурч боловсрох эрхийг хангахаас гадна хүчирхийлэл үйлдэгчдэд хуулийн хариуцлага хүлээлгэх, тэдний зан үйлд нөлөөлөх зэрэг олон асуудлууд нь салбар хоорондын уялдаа холбоо, оролцоог шаарддаг. Эдгээр асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэхэд нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, мэргэжилтнүүдийг татан оролцуулж, хуулиар хүлээсэн ажил үүргийн хүрээнд уялдаа холбоотой ажиллаж, цогц үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ шаардлага зайлшгүй гарч ирдэг.

Хүчирхийлэлд өртөж гэмтэж бэртсэн хохирогчид ихэвчлэн эмнэлэг, цагдаагийн байгууллагад ханддаг. Дээрх байгууллагуудын авч хэрэгжүүлдэг арга хэмжээ болох биеийн эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, нөхөн сэргээх, хүчирхийлэл үйлдэгчийг архи хэрэглэсэн бол эрүүлжүүлэх, баривчлан саатуулах, торгох, эрүүгийн хэрэг үүсгэх, гэр бүл цуцлуулах хүсэлтээ шүүхэд гаргаж хүүхдийн хууль ёсны асран хамгаалагчийг тогтоолгож болох талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудад хандахыг зөвлөх зэрэг юм.

Хүчирхийлээс үүдэлтэй сэтгэл санаа, бие махбодын хохирол учирсан, амьдралд итгэх итгэл үнэмшлээ алдсан, өмгөөллийн туслалцаа хэрэгтэй зэрэг тохиолдолд болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалахын тулд хамтарсан баг ажилладаг.

Хүүхэд хамгааллын үндсэн асуудал бол бүх хүүхдийг хүчирхийлэл, дарамт, үл хайхралт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, нэгэнт өртсөн хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ, дахин өртөхөөс хамгаалж, хоёрдогч урьдчилан сэргийлэлт хийх явдал юм.



Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх нь салбар дундын хамтын ажиллагаа учир засаг захиргааны анхан болон дунд шатны нэгж дээр төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа аймаг, нийслэл, сум, хороо, багийн шат шатны Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмч, эрүүл мэндийн болон сургуулийн нийгмийн ажилтнууд албан ёсоор үйл ажиллагаагаа нэгтгэж, “Хамтарсан баг” байгуулан ажиллаж байгаа ч хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн, магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж, дэмжлэг туслалцааг авах хэрэгцээ шаардлага хуулийн дагуу тавигдаж байна.

10.2 Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага, эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас

Хүүхэд хамгааллын хамтарсан багт хүүхэд хамгааллын чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлсэнээр дараах асуудлуудыг шийдвэрлэх боломж бүрдэх юм. Үүнд:

Хамтарсан багийн үзүүлэх үйлчилгээ	Хамтарсан баг нь холбогдох төрийн бус байгууллагатай хамтран ажилласнаар дараах үйлчилгээг үзүүлж болно.
<ul style="list-style-type: none"> o Урьдчилан сэргийлэх үйлчилгээ хүргэх o Гэр бүлийн орчинд аюулгүй байдлыг хамгаалах o Эрсдлийн үнэлгээ болон нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн шүүхэд эрх хязгаарлах арга хэмжээ авах хүсэлт гаргах o Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ хүргэх o Хуулийн анхан шатны зөвлөгөө өгөх o Анхан шатны сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх o Дэмжих бүлэг ажиллуулах o Нийгмийн халамжийн үйлчилгээ хүргэх o Хоёрдогч урьдчилан сэргийлэлт гэх мэт 	<ul style="list-style-type: none"> o Үйлчлүүлэгчийг хамгаалах байранд байршуулах o Нарийн мэргэжлийн эрүүл мэндийн үзлэг оношилгоо хийлгэх o Өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх o Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх o Сэтгэл зүйн нарийн мэргэжлийн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх o Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалт явуулах o Амьдрах ухааны сургалт зохион байгуулах o Орлого нэмэгдүүлэх боломжоор хангах o Мэдлэг, ур чадвар, ажлын арга зүйд суралцахад дээшлүүлэхэд туслах o Урьдчилан сэргийлэх үйлчилгээг төлөвлөх, хамтран ажиллах гэх мэт

10.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллага болон хуулийн этгээд нь тусгайлан бэлтгэгдэж, мэргэшсэн хүний нөөцтэй байна.

10.4. Хүүхэд хамгааллын чиглэлээр хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас магадлан итгэмжлэгдсэний үндсэн дээр үйл ажиллагаа явуулах бөгөөд уг журмыг хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас

Төрийн бус байгууллага нь хамтарсан багийг мэргэжил арга зүйн дэмжлэгээр ханган хамтран ажиллах боломжтой бөгөөд хамтын ажиллагаа нь дараах чиглэлүүдээр хэрэгжих боломжтой юм.



ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГААС ХАМТАРСАН БАГТ КЕЙС ШИЛЖҮҮЛЭХ

II дүгээр зүйл. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах

II.3 Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх бөгөөд тухайн асуудлыг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагад заавал мэдэгдэнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллага тухайн үйлчлүүлэгчийг бүртгэж, үйлчилгээ үзүүлсэн кейсийг харьяалалын дагуу хамтарсан багаас кейс хүлээн авах, шилжүүлэх, үйлчилгээг дуусгах хүртэл хугацаанд хамтран ажиллах шаардлагатай болдог. Төрийн бус байгууллагад үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл ирвэл, үйлчлүүлэгчийг хүлээн авч, өөрийн байгууллагын нөөц, боломж, чадавхийн хүрээнд үйлчилгээ үзүүлж, бүртгэл баримтжуулалтыг хийдэг. Үүнд:

1. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, бүртгэл хөтөлж, кодлох
2. Нөхцөл байдлын үнэлгээ хийх
3. Нэн тэргүүнд аюулгүй байдлыг хангах, дахин хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
4. Ганцаарчилсан болон хамтарсан ярилцлагын тэмдэглэл хөтлөх
5. Үйлчлүүлэгчийн зөвшөөрөлтэйгөөр гэрэл зураг авах, бичлэг хийж баримтжуулах
6. Үйлчилгээний төлөвлөлт хийх
7. Үйлчилгээ үзүүлсэн бүхий л тэмдэглэл, тайлан
8. Хамтарсан баг болон бусад байгууллагад холбон зуучилсан бүртгэл
9. Гэр бүлд нь эргэн нэгтгэх олон хувилбарт үйлчилгээ гэх мэт

Дээрх баримтжуулалтыг хийсний дараа, үйлчлүүлэгчийн саналыг харгалзан, харьяа анхан шатны хамтарсан багт мэдээлж, кейсийг шилжүүлнэ. Кейсийг хүлээлгэн өгсөнөөс хойш дараах хэлбэрээр хамтын ажиллагааг үргэлжлүүлдэг. Үүнд:

1. Хамтарсан багийн үйлчилгээнд өөрийн байгууллагын зүгээс шаардлагатай үйлчилгээг үзүүлэх;
2. Хүүхдийг амьдарч буй орчинд нь хамгаалах;
3. Хоёрдогч урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад оролцох;
4. Үйлчилгээг үнэлэх, дүгнэх зорилгоор харилцан мэдээллээ солилцох, хамтын ажиллагааг дүгнэх, тайлагнах гэх мэт

11 дүгээр зүйл. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах.

11.4. Энэ зүйлд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж, холбогдох тэмдэглэлийг нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлнэ.

11.5. Хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ.

11.6. Хүүхдийг түр тусгаарлах шийдвэр гарах хүртэл хугацаанд тухайн мэдээ, мэдээллийг хүлээн авсан нийгмийн ажилтан, албан тушаалтан хуульд заасан боломжит арга хэмжээг гэр бүлийн бусад гишүүн, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ.

11.7. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ хуульд заасан тусгаарлах арга хэмжээг авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй.

11.8. Гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаархи мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан дангаар болон багаар газар дээр нь, эсхүл байгаа орчинд нь очиж үзэх, харилцан ярилцах хэлбэрээр шалгаж болно.

11.9. Энэ хуульд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээлэл хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийн шинжтэй бол хүүхдийн эрхийн ажилтан холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

11.10. Хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэргийг цагдаагийн байгууллагын алба хаагч холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас



ХАМТАРСАН БАГААС ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАД KEЙC ШИЛЖҮҮЛЭХ НЬ

Хамтарсан баг нь нутаг дэвсгэртээ хүчирхийлэлд өртсөн болон өртөх эрсдэлтэй хүүхэд, гэр бүлийн судалгааг тогтмол гаргаж, үйлчилгээ үзүүлэх шаардлагатай гэр бүл, хүүхдийг сонгон бүх нөөц боломжид тулгуурлан хамгааллын үйлчилгээ үзүүлнэ. Хороо/баг/сумын түвшинд хамтарсан багийн гишүүд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд мэргэжилтэнгүүдийн нөөц, боломж, ажлын чиглэлээс хамааран зарим үйлчилгээг үзүүлэх боломжгүй байх нь бий. Жишээлбэл сэтгэл зүйн зөвлөгөө, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нарийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх гэх мэт.

Үйлчлүүлэгчид дараах хэрэгцээ шаардлага гарч ирвэл, тухайн чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагатай холбогдон, хэрэгжүүлдэг үйл ажиллагаатайгаа уялдуулан холбон зуучилж, хамтран ажиллаж болно. Үүнд:

- Хохирогчийг хамгаалах байранд байрлуулах;
- Хохирогчдод нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх;
- Хүүхдийн утасны мэдээллийн дагуу туслалцаа үзүүлэх;
- Хохирогчид хууль, эрхзүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх;
- Хохирогчид сэтгэлзүйн болон сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх;
- Хүчирхийллийг даван туулагчдад зориулан өөртөө туслах болон дэмжих бүлгийн уулзалт зохион байгуулах;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх талаарх сургалт, сурталчилгаа, судалгааны үйл ажиллагаа явуулах, хууль сурталчлах;
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах;
- Нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх;
- Сэтгэл зүйн нарийн мэргэжлийн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх;
- Амьдрах ухааны сургалтад хамруулах;
- Орлого нэмэгдүүлэх боломжийг санал болгох;
- Ажил, ажлын байранд зуучлах, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Хамтарсан багийн гишүүдэд сургалт явуулах, чадваржуулах;
- Мөн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох зэргээр хороо/баг/сумын түвшинд ажиллаж байгаа хамтарсан багийг дэмжин ажиллах боломжтой.

Кейсийг хамтарсан багаас төрийн бус байгууллагад шилжүүлэх, төрийн бус байгууллагаас хамтарсан баг руу шилжүүлэхдээ холбон зуучлах үйлчилгээний хуудас бөглөнө. Мөн тухайн хариуцаж буй мэргэжилтэн заавал өөрийн биеэр хүлээлгэж өгнө гэдгийг анхаарах нь чухал. Хамтарсан багийн хүсэлтийн дагуу холбогдох төрийн бус байгууллага нь кейсийг хүлээн авсан ч хамтарсан баг нь тухайн үйлчлүүлэгчид үзүүлэх үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

13 дугаар зүйл. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах

13.1. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдлын үнэлгээг харгалзан Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаас гадна хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах арга хэмжээг авна.

13.2. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээг төрийн байгууллага, эсхүл магадлан итгэмжлэгдсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэгч, хуулийн этгээд, гэр бүл, иргэн, эсхүл тэдгээр нь хамтран үзүүлнэ.

13.3. Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний стандартыг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална.

13.4. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд хувилбарт үйлчилгээ үзүүлэх санал, дүгнэлтийг хамтарсан баг, нийгмийн ажилтан гаргах бөгөөд гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хүүхдийн эрхийн ажилтан хяналт тавина.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас...

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ НЬ

Төрийн бус байгууллагууд хамтарсан багтай олон нийтэд чиглэсэн урьдчилан сэргийлэх нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломжтой. Үүнд:

- Хамтарсан багийн эрхзүйн орчныг боловсронгуй болгоход шийдвэр гаргагчдад нөлөөлөн ажиллах;
- Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих арга зүйн зөвлөгөө өгөх;
- Хамтарсан багийг чадавхижуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалт зохион байгуулах;
- Хүүхэд хамгаалалд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэдтэй зүй бус харьцах бүх хэлбэрийг устгах кампанит аян өрнүүлэх;
- Хамтарсан багийн ажил үйлчилгээний чанарт хяналт тавьж, үр дүнг үнэлэн дүгнэх, судалгаа хийж, олон нийтэд нээлттэй танилцуулах



ТББ НЬ ХАМТАРСАН БАГИЙГ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ДЭМЖИН АЖИЛЛАХ НЬ

Хамтарсан баг нь хүүхэд хамгааллын үйлчилгээний анхан шатны үйлчилгээг хариуцна. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхэд хамгааллын зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох, бүртгэх, баримтжуулах, хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэхэд хамтарсан багт дэмжлэг үзүүлэн ажиллаж болно. Дээрх үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлвол:

- **Хамтран ажиллах стратегиа тодорхойлох:** Кейс дээр болон орон нутгийн онцлогт тохирсон гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаарх нийгэмд тогтсон уламжлалт үзэл хандлагыг өөрчлөхөд нөлөөлөхүйц урьдчилан сэргийлэх агуулга бүхий сургалт, сурталчилгааны урт хугацааны тасралтгүй үргэлжлэх стратеги боловсруулан ажиллах;
- **Судалгаа хийх:** Баг, хороон дээр нийгмийн ажилтан, хэсгийн байцаагчид голлох үүрэг гүйцэтгэн, бусад гишүүд мэдээллээр хангах үүрэгтэйгээр:
 - Ойр орчиндоо түгшүүр төрүүлдөг гишүүнтэй айл өрх
 - Архины хамааралд хэт орсон гишүүнтэй айл өрх
 - Хорихоос өөр төрлийн ял эдэлж буй хүмүүс
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд
 - Шинээр шилжин суурьшиж буй айл өрх
 - Үндэсний цөөнх
 - Сургуулиас завсардсан хүүхэд
 - Хөдөлмөр эрхэлж буй хүүхэд
 - Бусад шаардлагатай асуудлаар нарийвчилсан судалгаа гаргах

Энэхүү судалгаанууд нь хүүхэд болон гэр бүлийн эсрэг хүчирхийллийг илрүүлэхэд, мөн хамтран ажиллах үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, төлөвлөлт хийхэд ач холбогдолтой. Судалгааг холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран хийж болно.

- **Үйлчилгээний зураглал гаргах:** Гэр бүлд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний зураглалыг өөрийн нутаг дэвсгэрт болон хот, аймаг, улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг байгууллага, албан тушаалтан, мэргэжилтнүүдтэй холбоо тогтоож, багийн хүрээг өргөжүүлэх зорилгоор нарийвчлан боловсруулах;
- **Мэдээлэл түгээх:** Иргэдэд хэрэгцээт мэдээллийг энгийн, ойлгомжтой хэлбэрээр хүргэх; (нийгмийн сүлжээ, амаар, бичгээр, ном, гарын авлага, тараах материал, мөн тогтмол ажиллах мэдээллийн самбараар дамжуулан)
- **Анхан шатны зөвлөгөө өгөх:** Хохирогчид сэтгэл зүй, хууль, эрүүл мэнд, сурган хүмүүжүүлэх болон бусад хэрэгцээт зөвлөгөөг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно. Үүний тулд үйлчлүүлэгчид ганцаарчилсан зөвлөгөө өгөх нөхцлийг бүрдүүлэх ёстой. Жишээлбэл: Төрийн бус байгууллагын зөвлөгөөний өрөөг хэрэглэх бөгөөд үйлчилгээ хүсэгчтэй ганцаарчлан уулзаж, хүсэлт, санал, гомдлыг хүлээн авч, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх

наад захын орчинг бүрдүүлж болно.

- **Бүлгээр зөвлөгөө өгөх:** Хүүхэд, ээжүүд, аавууд, гэр бүл, архины хамаарлаас гарахыг эрмэлзэгч иргэдийн гэх мэт тусгай хэрэгцээн дээр үндэслэн, дэмжих бүлэг ажиллуулж, бүлгийн сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэхдээ энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтрах
- **Хүчирхийллийн кейс дээр хамтран ажиллах:** Хамтарсан багийн гишүүд өөр өөрсдийн ажил үүргийн дагуу кейсийг шийдвэрлэхэд оролцож, кейсийг хаах хүртэл хамтран ажиллана. Үүний тулд:
 - Үйлчлүүлэгчийн асуудлыг илрүүлэх
 - Мэдээлэл хүлээн авах, цуглуулах
 - Асуудлыг шуурхай таслан зогсоох
 - Бүртгэл хөтлөх, баримтжуулах
 - Эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх
 - Үйлчилгээний төлөвлөгөө гаргах
 - Үйлчилгээний хэрэгжилтийг хангах, хянах, үйлчлүүлэгчтэй эргэх холбоотой ажиллах
 - Кейсийг хаах зэрэг нийгмийн ажил үйлчилгээнд мөрддөг үйл явцын дагуу хамтран ажиллана.
- **Сургалт:** Хүүхэд, эцэг эх, олон нийтэд чиглэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг төлөвлөн, хамтарсан багийн гишүүд болон бусад мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийг урьж оролцуулан сонирхолтой байдлаар зохион байгуулах;
- **Сурталчилгаа:** Хороо, багийн янз бүрийн сэдэвт өдөрлөг, үдэшлэг, баяр ёслолын арга хэмжээг тохиолдуулан сурталчилгааны олон талт үйл ажиллагаа явуулах;
- **Олон нийтийн оролцоог дайчлах:** Гэр бүл хүчирхийлэл, дарамтаас ангид аюулгүй амьдрах эрх, хүүхэд хамгаалалд онцгой анхаарч, олон нийтийн оролцоог дайчлах, хүүхдийн оролцоог бий болгох, чадавхижуулах;
- **Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах:** Хамтарсан багийн гишүүд кейсийг шийдвэрлэхэд холбон зуучлах, сургалт сурталчилгаа явуулах, мэдээлэл авах, зарим нэгэн дээд шатны шийдвэр гаргагчидтай холбоотой асуудлаар холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах нь чухал. Аль болох олон салбарын мэргэжилтнүүдийг үйл ажиллагаандаа татан оролцуулсанаар үйлчлүүлэгчид тулгарсан асуудлыг цогц байдлаар, үр дүнтэй шийдэж чадна. Үүний тулд холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, байнгын харилцаатай байх, тодорхой сэдвээр кампанит ажил зохион байгуулах, харилцан мэдээлэл, туршлага солилцох, кейс дээр хамтран ажиллаж, шийдвэрлүүлэхэд нөлөөлөх, үйлчлүүлэгчийн эрх, ашгийн үүднээс практик, бодлого, эрхзүйн орчныг боловсронгуй болгохоор нөлөөллийн ажил явуулах зэргээр хамтран ажиллаж болно.

ХАМТАРСАН БАГИЙГ СУМ, ДҮҮРГИЙН ТҮВШИНД АЖИЛЛАХАД ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ

Дунд шатанд байгуулагдах хамтарсан багийн бүрэлдэхүүнийг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс/төв, сум, дүүргийн цагдаа, эмнэлэг, боловсролын холбогдох албан тушаалтан, хороо, багийн нийгмийн ажилтнуудыг хариуцсан мэргэжилтэн, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын төлөөлөл, өмгөөлөгч зэрэг гэр бүл, хүүхдийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтэн, зөвлөхүүдээс бүрдүүлвэл илүү ач холбогдолтой.

- Дунд шатанд байгуулагдсан хамтарсан багт зөвлөх, удирдлага аргагүйгээр хангах баг нь хүүхэд хамгааллын чиглэлээр төрөөс баримтлаж буй бодлого, хөтөлбөрийг тухайн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангаж, тэргүүлэх чиг үүрэгтэй ажиллана.
- Орон нутгийн түвшинд мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах, анхан шатны шууд үйлчилгээ үзүүлэх хамтарсан багийг мэргэшүүлэх, арга зүйгээр хангах;
- Хороо баг дээр ажиллах хамтарсан багийг мэргэжлийн удирдлагаар хангах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- Орон нутгийн хэмжээнд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн нөхцөл байдлын судалгааг байгууллага тус бүрийнхээ мэдээлэл, бүртгэлд үндэслэн хийх, хариу арга хэмжээг төлөвлөж, бодлого тодорхойлох багт хүргүүлэх;
- Ноцтой кейсийг шийдвэрлэхэд оролцох, дэмжлэг үзүүлэх;
- Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах, хариуцлагатай байхад анхаарч, зөвлөгөө туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг гүйцэтгэнэ.



ХАМТАРСАН БАГИЙГ АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТҮВШИНД АЖИЛЛАХАД ХАМТРАН АЖИЛЛАХ НЬ

Хүүхэд хамгааллын асуудал нь өөрөө салбар дундын асуудал учраас олон салбарыг хамардаг, анхан шатны нэгжээс дээд шатандаа хүртэл үйл ажиллагаагаа уялдуулах, хамтрах шаардлага зүй ёсоор урган гардаг. Сум, дүүрэг, хороо, багт ажиллах Хамтарсан багуудыг бодлогоор хангах зорилгоор холбогдох албан тушаалтнуудаас бүрдсэн бодлого тодорхойлох баг бүрдүүлэх нь чухал. Үүрэг хариуцлагаа тодорхой байлгах үүднээс тус багийг аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс хариуцаж, бүрэлдэхүүнд нь нийгмийн хамгаалал, халамж, эрүүл мэнд, боловсрол, хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Хууль зүйн хэлтэс, харьяа Цагдаагийн хэлтсийн дарга, Хэв журмын хэлтсийн дарга, мөн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл орж болно. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хамтарсан багийн бодлого тодорхойлох баг нь:

- Харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2007), Гэр бүлийн талаар төрөөс баримтлах бодлого (2003), Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, Хүүхэд хамгааллын стратеги (2010) зэрэг хууль тогтоомжуудын хүрээнд төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах; (ГБХТ хууль 8.1.1)
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж, санхүүжүүлэх; (ГБХТ хууль 8.1.2)
- Хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллаж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг дэмжин ажиллах талаарх ГБХТХ-ийн заалтыг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх;
- Аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарга нар харьяа хэлтсээр дамжуулан Хамтарсан багийн гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод Хамтарсан багт тэдний гүйцэтгэх ажил үүргийг оруулан баталгаажуулах;
- Хамтарсан багийн гишүүдийн ажлыг дүгнэх, үнэлэх, урамшуулах, хариуцлага тооцох механизмыг бий болгох зорилгоор бүтээгдэхүүн нийлүүлэх, үр дүнгийн гэрээнд асуудлыг тусгуулахад нөлөөлөх;
- Хамтарсан багийн ажиллах журмыг боловсруулж батлах, мөрдүүлэх;
- Анхан шатны Хамтарсан багийн ирүүлсэн судалгаанд үндэслэсэн бодлогын арга хэмжээ авах;
- Аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын Газрын дэргэд “Гэр бүлийн хөгжлийн төв”-ийг байгуулж, нийгмийн ажилтан ажиллуулж, уг төвөөс хороо, багийн Хамтарсан багийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах нь зүйтэй. Энэхүү арга хэмжээг эхний үед төслийн үйл ажиллагаагаар дэмжиж, дараа жилээс төсөвт суулгаж, орон тоогоор ажиллуулах боломжтой гэж үзэж байна.

ХАМТАРСАН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТӨД ОРОЛЦОХ НЬ

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажил нь гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын гол суурь болдог. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд хэдий чинээ хүч зарцуулна, төдий чинээ нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг дагаж буурдаг гэж судлаачид үздэг байна.

Манай анхан болон дунд шатны засаг захиргааны нэгж дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь сайн зохион байгуулагддаг, гүйцэтгэх механизм нь тодорхой уламжлалт ажлуудын нэг юм. Иймээс гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх Хамтарсан багийн ажлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын төлөвлөгөөнд оруулж, үе шаттай зохион байгуулж болно.

Хүчирхийлэлтэй харилцааны улмаас тухайн гэр бүлийн гишүүдийн үндсэн эрх зөрчигдөж, шийдвэрлэвэл зохих олон асуудлууд хуримтлагдсан байдаг. Иймээс хуулиар үүрэг хүлээсэн ганц нийгмийн ажилтан, эсхүл цагдаагийн ажилтан дангаараа, тус тусдаа үйлчилгээ үзүүлээд хүссэн үр дүнг авчирч чадахгүй. Тухайлбал, гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн зөвхөн нэг кейс дээр ажиллахад дараах арга хэмжээг яаралтай авах шаардлагатай байдаг. Үүнд:

- Хүчирхийллийг шуурхай таслан зогсоох, хүчирхийллийн болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх;
- Гэр бүлийн гишүүдэд хэрэгцээт мэдээлэл өгөх;
- Сэтгэл зүйн тэнцвэрт байдлаа алдсан хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх;
- Гэр бүлийн гишүүдийн хэрэгцээнд үнэлгээ хийж, тэдний онцлогт тохирсон богино ба урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх буюу холбогдох байгууллагад холбон зуучлах;
- Зөрчигдсөн эрхийг нь сэргээлгэх, хамгаалахад чиглэсэн эрх зүйн туслалцаа үзүүлэх;
- Хүүхдийн эрхийг хамгаалах талаар сургууль, хамт олонтой нь ажиллах;
- Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж хамгааллын үйлчилгээнд хамруулах;
- Хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох болон зан үйлийг нь өөрчлөхөд нөлөөлөх зэрэг олон асуудлыг нэгэн зэрэг шийдвэрлэх үйл ажиллагаанууд хэрэгтэй болдог.

Дээрх үйл ажиллагаануудын алинд ч төрийн бус байгууллагууд оролцох боломжтой бөгөөд үйлчилгээний үр дүнд хариуцлага хүлээх үүднээс гэрээ байгуулж ажиллах хэрэгтэй.

ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, үүргийг тодорхойлж өгсөн байдаг. Тухайлбал: Гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл өгөх эрхийг баталгаажуулж өгснөөс гадна хохирогчийн аюулгүй байдлыг хангахад оролцох, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцох, улмаар нууцлал хадгалах зэрэг үүрэг хүлээж байдаг.

Хуулиар тусгайлан үүрэг хүлээж байгаа төрийн үйлчилгээний байгууллага төдийгүй төрийн бус байгууллага, иргэд, бизнесийн байгууллага ч хамтран ажиллах боломжийг шинээр нээж өгсөн бөгөөд энэ нь үйл ажиллагааны цар хүрээгээ өгсөн нэмэгдүүлэх боломж юм.

Орон нутгийн засаг захиргаа нь харьяа нутаг дэвсгэртээ гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, арга хэмжээний зардлыг мэдээ, судалгаанд үндэслэн орон нутгийн төсвөөс тусгайлан төлөвлөж, санхүүжүүлэх үүргийг хүлээж байдаг.

Мөн одоогийн төсвийн уламжлалт хэсэг болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал, Засаг даргын нөөц зардал, холбогдох үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зардал, гадаад, дотоодын төрийн бус байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр зэргээс тухайн Хамтарсан баг өөрсдөө эрэл хайгуул хийж, хөрөнгө, нөөцийг дайчлах тусгай төлөвлөгөө гарган, төсвөө бүрдүүлэх боломжтой.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлын хүрээнд хийгдэх ажил, тэр дундаа хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдэд чиглэсэн дэмжлэг нь төрөөс албан ёсоор зохион байгуулагдах ёстой. Энэ нь тусгай судалгаа, тайланд үндэслэж, өөрийн төсөвлөгдсөн зарцуулалт бүхий хөрөнгийн эх үүсвэртэй байна. Иймд орон нутаг бүр өөрийн өвөрмөц онцлогийг харгалзсан үйл ажиллагааг төлөвлөн, Хамтарсан багийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх боломжтой.

ХОХИРОГЧИЙГ ДЭМЖИХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ

“Хохирогчид үзүүлэх үйлчилгээ” гэж хохирогчид хэрэгцээтэй мэдээлэл, эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн тэнцвэрт байдлаа түр алдаж, хямарсан үед эмчилгээ хийх, нөхөн сэргээх үйлчилгээг хэлнэ.

Эдгээр үйлчилгээнүүдийг засаг захиргааны анхан шатны нэгж дээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад хуулиар хохирогчдод үйлчлэх үүрэг хүлээсэн ажилтнууд үзүүлнэ. Энэхүү үйлчилгээг холбогдох төрийн бус байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА МЭРГЭШИН АЖИЛЛАХ НЬ

Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх асуудал нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх суурь болохын зэрэгцээ төрийн нийгмийн үйлчилгээ, эрх зүйн үйлчилгээний гол хэсэг нь болж, цаашид төрийн бус байгууллагыг мэргэшин хөгжих боломжийг олгож буй учраас тухайн чиглэлээр мэргэшин ажиллах, магадлан итгэмжлэгдэх шаардлага хуулийн дагуу тавигдаж байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР ТӨРӨЛ, ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ТАЛААР

- Кейсээр дамжуулан гэр бүл, хүүхдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлон гаргаж ирэхэд нөлөөлөх;
- Хуулиар тусгай эрх, үүрэг хүлээсэн албан тушаалтнуудын ажиллах боломж, нөхцлийг бий болгоход чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах;
- Үйлчлүүлэгчийн болон гэр бүлтэй холбогдох хувийн нууцлалыг чанд хадгалах, ёс зүйн хүрээнд ажиллах;



ХАМТАРСАН БАГ - ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА		
СУМ, ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД:	АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТҮВШИНД:	ЗАСГИЙН ГАЗРЫН ТҮВШИНД:
<p>Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг сум дүүргийн хэмжээнд төлөвлөхдөө төрийн захиргаа, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хамгаалал, хуулийн байгууллагын оролцоотойгоор хамтарсан төлөвлөгөө гаргаж, жил бүр үр дүнг тооцож байх нь чухал.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дэргэдэх Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах; ▪ Гэр бүлтэй ажилладаг мэргэшсэн нийгмийн ажилтны орон тоог бий болгох; ▪ Нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээтэй зэрэгцүүлж, нөхөн сэргээх, сэтгэл заслын үйлчилгээгээр дагнан мэргэшиж, үйлчилгээг гэрээлэх, зарим тохиолдолд төлбөрт үйлчилгээг санал болгох 	<p>Тухайн жилд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны бодлого, стратегийг төрийн захиргаа, стратеги удирдлагын, нийгмийн хөгжлийн хэлтсүүд болон хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын оролцоотойгоор орон нутгийн онцлог хэрэгцээтэй уялдуулан тодорхойлоход төрийн бус байгууллагууд санал хүсэлтээ хүргүүлж болно.</p> <p>Гэр бүлийн болон хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны зардлыг жилийн төсөвт суулгахад үйлчилгээгээрээ дамжуулж нөлөөлөх хэрэгтэй.</p> <p>Ингэснээр Хамтарсан багуудын үйл ажиллагааг идэвхижүүлэх, үр дүнтэй ажиллах боломжийг бий болгоно. Салбар хоорондын уялдааг хангаж, зохицуулалтыг тухайн орон нутгийн нийгмийн хөгжлийн хэлтсийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ▪ Хохирогчид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг зохион байгуулах; ▪ Амь нас, эрүүл мэндэд нь аюул занал тулгарсан хохирогчдын аюулгүй байдлыг хамгаалахын тулд түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах; ▪ Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл засах албадан сургалтыг зохион байгуулах; ▪ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр мэргэшин ажилладаг ТББ-тай хамтран ажиллах, гэрээгээр үүрэг гүйцэтгүүлэх; ▪ Хуулиар хүлээсэн бусад чиг үүрэг; 	<p>Хүн ам, Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хууль зүй, дотоод хэрэг, эрүүл мэнд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний бодлого стратегийг тодорхойлж, салбар дундын зохицуулалтыг хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах тухай Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолд тусгаж өгсөн байдаг.</p> <p>Хохирогч, хүчирхийлэл үйлдэгчдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний стандарт, удирдамжийг баталж, мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих нь бас энэ байгууллагын бүрэн эрхийн хэмжээнд хэрэгжих ёстой.</p> <p>Эдгээр үйл ажиллагааны хүрээнд ТББ-ууд санал хүргүүлж ажиллаж болно.</p>



Хүүхэд хамгааллын тогтолцооны загварыг (хүүхэд хамгааллын хамтарсан багийг) анхан шатны нэгжид (нийслэл, дүүрэг хороонд, орон нутаг сум, багт) бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2,10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9,10-р хороо болон Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл сум, Эрдэнэбулган сумын 4-р багийг сонгон хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2015- 2018 оны хооронд ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжих юм.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

Үйл ажиллагаа 1: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үйл ажиллагаа 3: Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 4: Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны сургамж, хүрсэн амжилт, үр дүнд үндэслэн холбогдох яамдад нөлөөлөх

Төслөөс хүлээж буй үр дүн:

- Хамтарсан багийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, зорилтот орон нутаг дахь хүүхдүүдэд хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо зохицуулалтыг хангах механизм бий болж, бэхжиж хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна зорилтот орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломж нэмэгдэнэ.
- Хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүд ба тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын харилцааг сайжруулахад дэмжих, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.
- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн байгууллагуудын зүгээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд ач холбогдол өгч ажиллах нь нэмэгдсэн байна.